

ОРШИЛ

“Ай Би Би Ай” ХХК нь MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд 2015-2016 онуудад галтын амны дээд хэсгийн алтны шороон орд, туул дэнжийн алтны шороон хуримтлал гэсэн хоёр хэсэгт геологи хайгуулын ажлыг явуулж, өрөмдлөгийн торыг нягтруулан судалж улмаар ордын нөөцийг бодитой В зэргээр, илрүүлэгдсэн баялаг Р1 зэрэгт хамааруулан тооцоолсон.

Бид Төв аймгийн Замаар сумын нутагт орших "Галтын Ам"-ны алтны шороон ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөнд бодитой хувь нэмэр оруулах, үйлдвэрлэлийн хаягдал багатай шинэ техник технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шинэ дүрэм журам нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт анхаарал хандуулан ажиллаж байна.

Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа нутаг юм.

2016 онд нарийвчилсан хайгуулын ажил явуулж ЭБМЗ-өөр нөөц батлуулан 2017 онд ТЭЗҮ батлуулсан. Уг ТЭЗҮ-ээр 3 жил ашиглахаар төлөвлөгдсөн ба үүнийг 2018-2020 онд ашиглаж дууссан.

2018 онд нарийвчилсан хайгуулын ажил нэмж явуулан 2020 онд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн 394,86 мян.м3 элс, 470,79 кг алтны нөөц батлуулсан. Уг батлагдсан нөөцийн хэмжээнд Голдмэн прожект ХХК-аар ТЭЗҮ боловсруулуулан 5 жилд 391,73 мян.м3 элс олборлон баяжуулж 425,51 кг алт олборлохоор төлөвлөсөн.

2023 онд Галтын амны дээд хэсгийн гүний В-1, Галтын амны Туул дэнж ордын В1-В2-р блокуудыг бүрэн олборлохоор төлөвлөж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор Галтын амны дээд хэсгийн гүний ордын хэсэгт 4,9 га, Галтын амны Туул дэнж ордод 7,2 га, нийт 12,1 га талбай уурхайн олборлолтонд, 1,0 га талбай шимт хөрсний овоолгод, 0,8 га талбайд уурхайн зам хийхэд, 9,9 га талбай гадаад овоолго хийхэд ашиглагдана.

Ил уурхайн уулын ажлыг тээвэрлэлтийн системээр экскаватор, автосамосвалын хослолын ашиглалтын системээр гүйцэтгэнэ.

Галтын амны дээд хэсгийн алтны шороон орд нь 2023 оны 4-11 саруудад ажиллана. Уулын ажил хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна.

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

Галтын амны дээд хэсгийн алтны шороон ордыг ашиглах төсөл

Төслийн зорилго, ач холбогдол:

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар төсөл хэрэгжүүлэх 5 жилийн хугацаанд 391,73 мян.м3 элс угаан баяжуулж, 425,51 кг алт борлуулах ба тодорхой тооны хүмүүсийг ажлын байраар ханган, өөрийн компанийн болон улс, орон нутгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, Ашигт малтмалын тухай хуулийн 35.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглахад чиглэгдэнэ.

Төсөл хэрэгжүүлэгч:

“Ай Би Би Ай” ХХК, Захирал: Ч.Оюунгэрэл

Улсын бүртгэлийн дугаар: 9011453143

Регистрийн дугаар: 5809797

Утас: 99113446

Төслийн байршил:

Галтын амны MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Монгол Улсын засаг захиргааны нэгжийн хувьд тэрээр Төв аймгийн Заамар сумын нутагт оршино. Тус орд нь Улаанбаатар хотоос 195 км, Заамар сумаас 35 км-т оршино.



Ордын байршил:

Тусгай зөвшөөрөл нь байр зүйн хувьд М-48-137 хавтгайд нийт 3506,94 га талбайг хамрах ба газар зүйн солбилцлыг хүснэгт № 1-д үзүүлэв.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн солбицол

№	Булангийн цэг	Уртраг	Өргөрөг
1.	5336546.924 454148.257	104° 22'59.42"E	48° 10' 28.59"N
2.	5335886.802 454726.797	104° 23'27.69"E	48° 10' 38.49"N

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.	5336171.411	457469.644	104° 25'40.4"E	48° 10'49.82"N
4.	5331442.988	457308.808	104° 25' 34.32"E	48° 8'5.31"N
5.	5331434.604	448909.547	104° 18'47.94"E	48° 8'2.81"N
6.	5331790.894	448912.727	104° 18'47.94"E	48° 8'14.35"N
7.	5331791.924	448797.412	104° 18'42.36"E	48° 8'17.79"N
8.	5331898.132	448798.362	104° 18'42.36"E	48° 8'14.35"N
9.	5331899.864	448605.141	104° 18' 33.01"E	48° 8'17.79"N
10.	5331976.123	448605.825	104° 18' 33.01"E	48° 8' 20.26"N
11.	5331977.584	448443.398	104° 18'25.15"E	48° 8'20.26"N
12.	5332859.356	448451.342	104° 18'25.15"E	48° 8'48.82"N
13.	5332860.561	448317.866	104° 18'18.69"E	48° 8'48.82"N
14.	5333302.991	448321.862	104° 18'18.69"E	48° 9'3.15"N
15.	5333303.854	448226.412	104° 18' 14.07"E	48° 9'20.5"N
16.	5333839.525	448231.26	104° 18' 14.07"E	48° 9'3.15"N
17.	5333838.434	448351.905	104° 18'19.91"E	48° 9'20.5"N
18.	5333877 .336	448352.256	104° 18'19.91"E	48° 9'21.76"N
19.	5333876.77	448415.057	104° 18'22.95"	48° 9'21.76"N
20.	5333934.505	448415.578	104° 18'22.95"E	48° 9'23.63"N
21.	5333934 .062	448464.744	104° 18'22.95"E	48° 9'23.63"N
22.	5334003.529	448465.37	104° 18'25.33"E	48° 9'25.88"N
23.	5334003.081	448515.155	104° 18' 25.33"E	48° 9'25.88"N
24.	5334742.215	448521.809	104° 18'27.74"E	48° 9'49.82"N
25.	5334740.884	448669.906	104° 18' 27.74"E	48° 9'49.82"N
26.	5333876.399	448662.147	104° 18' 34.91"E	48° 9'21.82"N
27.	5333859.247	450610.012	104° 18'34.91"E	48° 9'49.82"N
28.	5334723.733	450617.478	104° 20'0.92"E	48° 9'21.82"N
29.	5334707 .687	452511.76	104° 20'0.92"E	48° 9'49.82"N
30.	5336560.161	452527.147	104° 21'40.91"E	48° 10' 49.82"N

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Уурхайн хүчин чадал

2023 онд Галтын амны дээд хэсгийн гүний В-1, Галтын амны Туул дэнж ордын В1-В2-р блокуудыг бүрэн олборлохоор төлөвлөж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор Галтын амны дээд хэсгийн гүний ордын хэсэгт 4,9 га, Галтын амны Туул дэнж ордод 7,2 га, нийт 12,1 га талбай уурхайн олборлолтонд, 1,0 га талбай шимт хөрсний овоолгод, 0,8 га талбайд уурхайн зам хийхэд, 9,9 га талбай гадаад овоолго хийхэд ашиглагдана.

Уурхайн олборлолтын талбайгаас 47,6 мян.м³ өнгөн хөрс, 4537,87 мян.м³ үндсэн хөрс хуулан дунджаар 0,897 мг/м³ агуулгатай 108,74 мян.м³ элс олборлон баяжуулж, химийн цэврээр 97,529 кг алт олборлохоор тусгаж байна. Уулын ажил явуулж байсан өмнөх жилүүдийн туршлага дээр тулгуурлан уулын ажлыг тээвэрлэлтийн журмаар дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

- Уулын ажил явуулах болон нөлөөлөлд өртөх талбайн 0,2-0,4м зузаантай шимт хөрсийг тусгай овоолго руу зөөвөрлөх
- Карьер руу орох замыг бэлтгэх
- Хөрс хуулалтын ажлыг доголоор явуулж гадаад болон дотоод хөрсний овоолгыг хийнэ.
- Элс олборлолтыг хэсэгчлэн овоолго руу зөөх
- Элсийг угаах төхөөрөмж рүү хүргэх

Ил уурхайн уулын ажлыг тээвэрлэлтийн системээр экскаватор, автосамосвалын хослолын ашиглалтын системээр гүйцэтгэнэ.

Галтын амны дээд хэсгийн гүний алтны шороон ордын олборлолтын ажил 2022 оны 4-12 саруудад ажиллана. Уулын ажил хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна.

Уулын ажлын үндсэн үзүүлэлтүүд

Хүснэгт №3

Хийгдэх ажлууд		Уулын ажил явуулах сарууд										Нийт
		Хэмжих нэгж	3	4	5	6	7	8	9	10	11	
Хөрс хуулалт	Шимт хөрс	мян.м ³	3.6	9.8			34.2					47.6
	Хучаас	мян.м ³	100	600	600	600	500	600	750	560	331	4537.8
Элс олборлолт		мян.м ³		12	15	15	15	15	15	13	8.74	108.74
Элс угаалт		мян.м ³		12	15	15	15	15	15	13	8.74	108.74
Далан суваг, зам талбай болон бусад ажил		га				0.5	0.5					1
		мян.м ³				100	50					150
Дундаж агуулга		г/м ³		0.776	0.788	0.766	0.951	0.906	0.957	1.084	0.983	0.897
Металл	химийн цэврээр	кг		9.315	11.82	11.49	14.268	13.588	14.361	14.09	8.592	97.529
Нөхөн сэргээлт	Догоод овоолгоор дүүргэлт хийх	га		0.1	0.2	0.3	0.4	0.5		0.5	0.5	2.5
		мян.м ³	100	600	600	600	400	500		560	331	2000
	Догоод овоолгын тэгшлэлт, хэлбэржүүлэлт	га					1	1				2
		мян.м ³					100	100				200
Гадаад овоолгын	га										0	
	мян.м ³										0	

МV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

тэгшлэлт, хэлбэржүүлэлт											
Шимт хөрсөөр хучих	га				2						2
	мян.м ³				6						6
Биологи	га				1						1

Уурхайн ашиглалтын систем

Уг орд нь ашиглалтын гүн ойролцоо, уул-геологийн нөхцөл харьцангуй энгийн тул тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашигладаг. Иймд бульдозероор эхэлж шимт хөрсийг ил уурхайн хил хүрээний гадна талд түрж шимт хөрсний овоолго үүсгэсний дараа түүний доорхи хөрс болон элсэн давхаргыг экскаватор-автосамосвалын хослолоор зөөж тээвэрлэнэ.

Үндсэн хөрсийг урьд жилд ашиглалтын үйл ажиллагаа явагдан үүссэн хоосон орон зай руу шууд дотоод овоолго хийнэ. Алт агуулсан элсийг угаах төхөөрөмж байрласан талбайд зөөвөрлөнө. Хөрсний дотоод овоолго байгуулах замаар нөхөн сэргээлтийн ажлыг давхар хийж явна. Энэ нь хөрс болон шимт хөрсний давхаргуудыг холихгүйгээр анх байсан төлөвт нь эргүүлэн оруулж нөхөн сэргээлт хийх боломжийг бүрдүүлнэ.

2.2. Уурхайн ажиллах горим

“Галтын ам” уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд 3-р сарын 20-ноос 11 сарын хооронд 260 хоног ажиллана.

2023 оны уурхайн ажиллах горим

Ажилбарын нэр	Нийт хоног
Жилийн хуанлийн өдөр	260
Баяр ёслолын хоног	8
Цаг агаарын хүндрэлтэй хоног	20
Ажиллах ажлын өдөр	232
Уурхайн бэлтгэл ажил	15
Шимт хөрс хуулах	7
Хөрс хуулалтын хоног	190
Элс олборлолтын хоног	45
Элс угаах хоног	76
Нэг хоног дахь ээлжийн тоо	2 ээлж
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	10 цаг
Дотоод овоолгоор дүүргэлт хийх	50
Дотоод овоолгоор дүүргэлт хийсэн талбайг хэлбэржүүлэх	10
Хөрсний гадна овоолгын зарим хэсгийг хэлбэржүүлэх	
Шимт хөрсний нөхөн сэргээлтийн ажил	
Биологийн нөхөн сэргээлтийн ажил	1

2.3. Усан хангамжын эх үүсвэр, усны хэрэглээ

Уурхайн ашиглалтын үед цэвэр усны үндсэн хэрэглэгчид нь элс угаан баяжуулах хэсэг, ажилчидын хотхон байна

Карьер болон орон байрны ундны усыг гүний ус болон гадаргын урсгал уснаас хангахаас гадна ариун цэврийн хяналтын шаардлагыг хангасан байна.

Угаах төхөөрөмжийн усан хангамжийг усан сан болон тунаагуураас хангах бөгөөд ууршилтын үр дүнд алдагдсан усны нөхөлтийг гадаргын усны урсац усаар хангана.

МV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны усны хэрэглээ

Хэрэглэгч		Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Зам усалгаа		м3	2000
Баяжуулах үйлдвэрийн хэрэглээ	Нийт ус	м3	434960
	Эргэлтийн	м3	347968
	Нөхөн сэлбэлтээр	м3	86992
Унд, ахуйн хэрэглээ		м3	4680
Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтэд хэрэглэх хэрэглээ		м3	1000
НИЙТ ХЭРЭГЛЭЭ		м3	442640

2.4. Цахилгаан хангамжийн үүсвэр

Галтын амны алтны шороон орд нь дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт орших бөгөөд төвийн эрчим хүчний эх үүсвэрээс өөрийн хөрөнгөөр салаалуулан өндөр хүчдлийн шугам татан авч ашиглаж байна.

Уурхайн тосгоны орон байр, баяжуулах цех ба засварын баазыг төвийн эрчим хүчний системээс хангана.

2023 оны цахилгаан хэрэглэгчид нь кемп, засварын газар, баяжуулах хэсэг байна.

Цахилгааны хэрэглээ

Хэрэглэгчдийн жагсаалт	Хэмжих нэгж	Тоон утга
Тосгоны хэрэгцээт чадал	кВт.цаг	120
Баяжуулах үйлдвэрийн хэрэгцээт чадал	кВт.цаг	465,35
Нийт хэрэглээ (тоолуурын заалт)	кВт/жил	1526865
Төлбөрийн хэмжээ	Сая.төгрөг	295,81

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

АЙ БИ БИ АЙ ХХК нь үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох эрсдэл буюу болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг зохион байгуулахад шатлалтайгаар бууруулах зарчмыг баримтална. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ. БОЯБ-ын стратегид дээрх сөрөг нөлөөллийг бууруулах шатлалыг дараах байдлаар тус тус тодорхойлсон байдаг.

1) Зайлсхийх – “Зайлсхийх арга хэмжээнүүд нь биологийн олон янз байдалд бодит нөлөөлөл үүсэхээс өмнө буюу олборлолтын болон баяжуулалт зэрэг уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхээс урьтан менежментийн өөрчлөлт хийх эсвэл тухайн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээнүүд юм. Үүнд өмнөх төлөвлөгөө үйл ажиллагаа, арга хэмжээг өөрчлөх шийдвэрүүд багтана”.

2) Багасгах – “Багасгах арга хэмжээнүүд нь аль хэдийн эхэлсэн олборлолтын болон боловсруулах үйл ажиллагааны үр дүнд биологийн олон янз байдалд учирч болох хохирлыг багасгаж болох арга хэмжээнүүд юм”.

3) Нөхөн сэргээх – “Нөхөн сэргээх арга хэмжээнүүд нь төслийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар нутгуудад аюулгүй, тогтвортой газрын төрх, тогтцыг бий болгох бэлтгэл ажлууд, ургамалжуулж амьдрах орчныг дахин сэргээх ажил. Амьдрах орчныг сэргээх арга хэмжээ нь нөхөн сэргээлтээс бага зэрэг ялгаатай тал бий, энэ нь тухайн амьдрах орчныг эвдрэлд өртөхөөс өмнөх бүхий л нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ”.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг Галтын амны шороон ордын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлохдоо БОНХС-ын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалын хавсралтад заасан аргачлалыг үндэслэжээ. Уг үнэлгээгээр:

Нөлөөлөлд өртөгч		Байгаль орчны сөрөг		
		Их	Дунд	Бага ба
Газрын гадарга	Барилга байгууламж, агуулах сав, тоног			Дунд
	Дэд бүтэц			Дунд
Уур амьсгал	Нүүрстөрөгчийн хийн ялгарал			Дунд
	Цаг агаарын нөхцөл төслийн үйл			Бага
Агаарын чанарт үзүүлэх нөлөө				Дунд
Газрын хэвлийд үзүүлэх нөлөө				Их
Гадаргын усанд үзүүлэх нөлөө				Бага
Газрын доорх усанд үзүүлэх нөлөө				Дунд
Хөрсөнд үзүүлэх нөлөө				Их
Ургамалд үзүүлэх нөлөө				Их
Амьтны аймагт үзүүлэх нөлөө				Дунд

Гэсэн үр дүн гарсан.

Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал

Төслийн үйл ажиллагаанаас экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг энэ хэсэгт хамруулсан.

Экосистемийн өөрчлөлт:

Олборлолтын ажлын технологи нь ил уурхайн аргаар ухаж ачих-гээвэрлэх гэсэн процессуудаас бүрдэнэ. Иймд геологийн тогтоцыг эвдэж өөрчлөх, газрын хэвлийн нөөц

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

баялгийг ашиглах явцад бий болох ихэнх нөлөөлөл нь шууд нөлөөлөлд хамаарна. Ашиглалтын хүчин чадал бага боловч тухайн орон нутгийн байгаль-экоосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрс, ургамлан нөмрөг, гадаргын усны нөөцөд шууд сөргөөр нөлөөлж буй эдгээр нөлөөлөл нь дунд хугацааны дунд хүчтэй нөлөөлөлд хамрагдах бөгөөд ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Түүнчлэн тоос шороо дэгдэн бичил уур амьсгалын нөхцөл богино хугацаагаар бага зэрэг өөрчлөгдөж болох юм.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт: Уурхайн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй юм. Иймд Монгол улсын Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд түүнийг сорчлон ашиглахыг хориглоно. Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүрийн уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: Уурхайн хэрэглээ, шатах тослох материал, хог хаягдал зэрэгтэй холбоотойгоор гадаргын ус болон хөрс бохирдсон тохиолдолд газрын доорх усны чанарт өөрчлөлт орж болзошгүй бөгөөд энэ нөлөөлөл нь дунд хугацааны, бохирдсон гадаргын болон газрын доорхи уснаас мал, амьтан, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үр дагавар нь дунд зэрэг учир эрчим нь дунд зэрэг байна.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор: Байгалийн тогтоц буюу газрын гадаргын хэлбэршилд сөрөг нөлөөлөл үзүүлэх бөгөөд 12м гүн, 7.56 га талбай бүхий газрын хэвлийн олборлолтонд өртөж, хөрсний овоолго үүсэх бөгөөд энэ тухайн нутгийн байгалийн унаган дүр төрх, ландшафтыг хүчтэй өөрчлөлтөнд оруулах боловч нөхөн сэргээлтийг бүрэн хийснээр сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах боломжтой. Тус ордын нутаг орчим тусгай хамгаалалтай газар нутаг байхгүй.

Нийгэм, эдийн засаг: Ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулахаас гадна 238 хүнийг ажлын байраар хангах ба ажлын байр нэмэгдэх нь тэдний амьжиргаанд тус нэмэр болж буй сайн талтай юм. Эдгээр нь шууд бөгөөд богино хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах, нөхөн сэргээлтийг стандартын шаардлагад нийцүүлэн боломжит хамгийн их хэмжээгээр хийхэд онцгойлон анхаардаг.

Манай компани байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэж, энэхүү биелэлтийн тайланг бичих.

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Агаарын чанар								
	Агаарт тоос босох	Салхи ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	Уурхайн карьер, тээврийн зам	-	Үйл ажиллагааны зардал	-	-	Салхи, хуурайшилт ихтэй өдрүүдэд	MNS 4885:2007
	Уурхайн олборлолт болон хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийнэ, зам усалгааг тогтмол хийнэ.	Уурхайн талбайн дотоод зам	м3/төг	79.53	2000	159,06	Зам арчилгааг сард нэг удаа, зам усалгааг тоосжилттой үед өдөр бүр	Монгол Улсын Агаарын тухай хууль; MNS4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага
	Машин техникийн яндангаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах	Техник, машин механизмуудын засвар үйлчилгээг тогтмол хийж сайн чанарын ШТМ ашиглах	Ил уурхай	-	Үйл ажиллагааны зардал	-	-	Үйл ажиллагааны туршид	MNS 5013:2009 MNS 5014:2009
	Нийт, мян.төг						159,060		
2.	Гадаргын ба газрын доорхи усны нөөц								
	Усны нөөцийг хамгаалах	Ахуйн хэрэглээний усыг ариг гамтай хэрэглэхэд ажилчдыг уриалах, сургалт зохион байгуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	-	100000	2	200,0	Үйл ажиллагааны туршид	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 33-1, 2,3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS4596:1998.

МУ-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Усыг бохирдлоос хамгаалах	ШТМ болон хог хаягдлыг эмх цэгцтэй байлгах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	-	50000	4	200,0	Үйл ажиллагааны туршид	
	Нийт, мян.төг						400,0		
3.	Хөрсөн бүрхэвч								
	Шимт хөрсийг хамгаалах	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	-	Үйл ажиллагааны зардал	-	-	Үйл ажиллагааны туршид	Ай Би Би Ай компанийн дотоод журмууд
	Хаягдлын овоолгийн шимэрхэг хөрсийг хамгаалах	Ашиглалт явуулах болон хаягдлын овоолго хийх талбайн үржил шимт хөрсийг тусад нь хуулж 3 м-ээс өндөргүй овоолон хадгалах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	-	Үйл ажиллагааны зардал	-	-	Үйл ажиллагааны туршид	
	Хөрсөн бүрхэвчийг бохирдуулахгүй байх	ШТМ-ын хадгалалт, хамгаалалтыг сайн байлгаж хөрсийг бохирдуулахгүй байх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	-	Үйл ажиллагааны зардал	-	-	Үйл ажиллагааны туршид	
	Засварын талбайн хөрсөн бүрхэвчийг бохирдуулахгүй байх	Машин механизмын засвар үйлчилгээг хатуу хучилттай талбайд хийх, засварын газар байгуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	-	500000	1	500,0	Үйл ажиллагааны туршид	
	Нийт, мян.төг						500,0		
4.	Газрын хэвлий								

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Газрын хэвлийн чулуулгийн үе давхаргыг аль болох хуучин хэвэнд оруулах	Уурхайн ухаашын уланд угаагдаж гарсан эфель гаалийг хийж дээрээс нь үндсэн хөрсөөр дүүргэлт хийж шимт хөрсөөр хучих	Уурхайлалтын үед	-	Үйл ажиллагааны зардал	-	-	Үйл ажиллагааны туршид	Ай Би Би Ай компанийн дотоод журмууд
	Газрын гадаргын элэгдлээс үүссэн гуу жалга судгийг орчин үеийн хэлбэрт оруулах	Гадаад овоолгын хэлбэржүүлэлтийг хийхдээ уржил шим багатай, байгалийн нөлөөгөөр эвдэрсэн, гуу жалгатай газрыг сонгон орчны гадаргуутай ландшафтын хэлбэршлийн хувьд нэгдмэл бүтэцтэй бий болгоход.	Уурхайлалтын үед	-	Үйл ажиллагааны зардал	-	-	Үйл ажиллагааны туршид	
	Нийт, мян.төг						0		
5.	Ургамлан нөмрөг								
	Нөхөн сэргээлтэд ашиглахаар хадгалсан шимт хөрсний уржил шимийг хадгалах Ургамлын нөмрөгийн ургац болон шим тэжээлийг нэмэгдүүлэх	Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах	Биологийн нөхөн сэргээлт	Ур-кг/төг Тариалалт, арчилгаа-хүн.өдөр/төг	20000	25	500,0	Тайлант жилд	Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008
	Техник тоног төхөөрөмжийн замбраагүй	Ургамлан нөмрөгийг устах, талхлагдахаас							

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	<i>хөдөлгөөний уршигаар ургамын нөмрөг талхлагдах</i>	<i>сэргийлж, хүн, техникийн хөдөлгөөнд хязгаарлалттай тавьж авто замуудаар зорчих хөдөлгөөнийг хэвшүүлж хяналт тавьж ашиглах, шороон асгацууд бий болгохгүй байх, талбайн ашиглалтын зохион байгуулалтыг сайжруулна.</i>	<i>Уурхайлалтын үед</i>	-	<i>Үйл ажиллагааны зардал</i>	-	-	<i>Үйл ажиллагааны туршид</i>	<i>Ай Би Би Ай компанийн дотоод журмууд</i>
	<i>Нийт, мян.төг</i>						<i>500,0</i>		
6.	<i>Амьтны аймаг</i>								
	<i>Амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин нь устгах,</i>	<i>Хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад онцгой анхаарч ажиллахын зэрэгцээ сургалт зохион байгуулах</i>	<i>Уурхайлалтын үед</i>	-	<i>100000</i>	<i>2</i>	<i>200,0</i>	<i>Үйл ажиллагааны зардал</i>	<i>Ай Би Би Ай компанийн дотоод журмууд</i>
	<i>Байгалийн аюулт үзэгдэл болон, идэш тэжээл, ундаалах ус зэрэг нь хомсдах</i>	<i>байгалийн гамшиг болон бусад аюулд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах, мөн тэр тал дээр ажилчдад сургалт явуулах,</i>	<i>Уурхайлалтын үед</i>	-	<i>100000</i>	<i>5</i>	<i>500,0</i>	<i>Үйл ажиллагааны зардал</i>	

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		<i>биотехнологийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх</i>							
	<i>Нийт</i>						<i>700,0</i>		

6. Нөхөн сэргээлтний төлөвлөгөө

<i>№</i>	<i>Нөхөн сэргээлтний зорилт</i>	<i>Нөхөн сэргээлтний арга хэмжээ</i>	<i>Хэмжих нэгж</i>	<i>Тоо хэмжээ</i>	<i>Нэгжийн зардал, мян.төг</i>	<i>Нийт зардал, мян.төг</i>	<i>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</i>	<i>Баримтлах эрх зүйн баримт бичиг</i>
	<i>1</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>	<i>5</i>	<i>6</i>	<i>7</i>	<i>8</i>
<i>1.</i>	<i>Техникийн нөхөн сэргээлт</i>	<i>Дотоод овоолгоор өмнө нь олборлосон талбай руу отвальдах замаар нөхөн дүүргэлт хийж шимт хөрсөөр хучина.</i>	<i>га</i>	<i>2,0</i>	<i>10000</i>	<i>20000</i>	<i>Жилд 1 удаа</i>	<i>Нөхөн сэргээлтний ажлын стандартууд</i>
<i>2.</i>	<i>Биологийн нөхөн сэргээлт</i>	<i>Олон наст ургамал тарих</i>	<i>га</i>	<i>1,0</i>	<i>4500</i>	<i>4500</i>	<i>Жилд 1 удаа</i>	
	<i>Нийт</i>					<i>24500,0</i>		

7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

<i>№</i>	<i>Дүйцүүлэн хамгаалах зорилт</i>	<i>Хамгаалах арга хэмжээ</i>	<i>Арга хэмжээний цар, хэмжээ</i>	<i>Тоо хэмжээ</i>	<i>Нэгжийн зардал, төг</i>	<i>Нийт зардал, мян.төг</i>	<i>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</i>	<i>Баримтлах эрх зүйн баримт бичиг</i>
	<i>1</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>	<i>5</i>	<i>6</i>	<i>7</i>	<i>8</i>
	<i>Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх</i>	<i>Техникийн нөхөн сэргээлт</i>	<i>Дүйцүүлэх</i>	<i>5,0</i>	<i>3000,0</i>	<i>15000</i>	<i>Жилд нэг удаа</i>	<i>Нөхөн сэргээлтний стандарт</i>

8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Нутгийн малчин өрхүүд	Галтын амны дээд хэсгийн алтны шороон ордын талбайд 2023 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах талбайн ойр орчимд нөлөөлөлд өртөх объект, малчин өрх байхгүй болно.	Лицэнзийн хэмжээнд	-			Жилд 1 удаа	
	Нийт							

9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд археологийн дурсгал байхгүй бөгөөд орд гарзын ашиглалтын явцад илрэвэл тухай бүрд мэргэжлийн байгуулагад мэдэгдэнэ. Нийт ажилчдад сургалт зохион байгуулна.	Лицэнзийн талбайн хэмжээнд	2	50000	100,0	Жилд 1 удаа	
2.	Палеонтологийн дурсгал	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд палеонтологийн олдвор байхгүй бөгөөд орд гарзын ашиглалтын явцад	Лицэнзийн талбайн хэмжээнд	2	50000	100,0	Жилд 1 удаа	

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		<i>илрэвэл тухай бүрд мэргэжлийн байгуулагад мэдэгдэнэ. Нийт ажилчдад сургалт зохион байгуулна.</i>						
	<i>Нийт</i>					200,0		

10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	<i>Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх</i>	<i>Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны заварчилгаанд хамруулах, Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах,</i>	<i>Уурхайн нийт ажилчдын хүрээнд</i>	-		<i>Үйл ажиллагааны зардал</i>	<i>Өдөр бүр ээлжинд гарах үед нь</i>	
2.	<i>Уул уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нарийвчлан тусгасан болно.</i>	<i>Уул уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нарийвчлан тусгасан болно.</i>	<i>Уурхайн бүс орчимд</i>	-		<i>Үйл Ажиллагааны Зардалд тусгасан</i>	<i>Үйл ажиллагааны туршид мөрдөж ажиллах</i>	
	Нийт					0		

11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	<i>Ахуйн</i>	<i>Хог хаягдлыг ангилж ялгаж 3 төрлийн хогийн сав байршуулж , нэгдсэн журмаар хог хаягдлыг сумын хогын цэгт гэрээний дагуу нийлүүлнэ.</i>	<i>Уурхайн кэмп дэх ажилчдын хүрээнд</i>	<i>1 удаа</i>	<i>280000</i>	<i>1</i>	<i>280,0</i>	<i>Жилд 1 удаа</i>	
2.	<i>Үйлдвэрийн</i>	<i>Гарсан төмрийн хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, аюултай хог хаягдал тусгай саванд байршуулна.</i>	<i>Агаар, хөрсний бохирдлоос сэргийлэх</i>	<i>1 удаа</i>	<i>100000</i>	<i>1</i>	<i>100,0</i>	<i>Жилд 1 удаа</i>	
3.	<i>Аюултай</i>	<i>Маашин механизмаас гарсан шатах тослох материалын хаягдал болон аккумулятор зэргийг тусгайлан зориулалтын саванд байршуулан тусгай газар тээвэрлэн хүргэнэ.</i>	<i>Уурхайн үйл ажиллагаа явуулах хэмжээнд</i>	<i>удаа</i>	<i>500000</i>	<i>3</i>	<i>1500</i>	<i>Улиралд 1 удаа</i>	
	Нийт						1880		

12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

МV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Уурхайн үйл ажиллагаанаас агаар орчинд тоосжилт үүсэх , түүнийг шинжлүүлэх	Уурхайн бүсийн зонхилох салхины дээд болон доод талд кэмп дээр	Жилд 2 удаа	2	50000	100,0		Агаарын тухай хууль, MNS 4585:2016 агаарын чанар
2.	Түвшиний шаталтаас үүсэх хорт хийгээр агаарын бохирдолтыг тодорхойлох. / SO ₂ , NO ₂	Уурхайн бүс болон паркийн талбай мөн кэмп дээр	Жилд 2 удаа	2	50000	100,0		SO ₂ , NO ₂ Тодорхойлох
3.	Хөрсний ялзмаг, механик бүрэлдэхүүн, давсны агууламж болон хөдөлгөөнт элемент тодорхойлох	Нөлөөлөлд өртөөгүй болон нөхөн сэргээлт хийгдсэн талбайнууд	Жилд 2 удаа	2	50000	100,0		Шимт хөрс хуулалт, хадгалалт MNS5918:2008
4.	Хөрсөн дэх тос тослох материалын болон хүнд металлын агууламжыг тодорхойлох	Уурхайн засварын төв, шатахууны агуулах, автомашины зогсоол	Жилд 2 удаа	2	50000	100,0		ШУА Газар зүйн хүрээлэнтэй хамтарч ажиллах
5.	Унд ахуйн усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоож хашаа барих	Ундны усны худгийн байршилд	Жилд 1 удаа	1	50000	50,0		
	Ундны ус, болон технологийн уснаас тус бүр дээжлэлт хийж шинжилгээнд хамруулна.	Ундны ус, болон тенологийн нуурнаас	Жилд 2 удаа	2	50000	100,0		
	Нийт					550,0		

13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Тайлбар
---	------------------------	---------------------	---------

МУ-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	2023 он			Хариуцсан албан тушаалтан	
			Сар ...	Сар ...	Сар ...		
	1	2	3	4	5	6	7
1.	Байгаль хамгаалах төлөвлөгөөнд заагдсан арга хэмжээний биелэлтийг хангуулах	Үйл ажиллагааны зардал	7	8	10	Уурхайн дарга болон байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	
2.	Уулын ажлын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар тодорхой ажлуудыг тусган түүнийг мөрдөн ажиллах	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны туршид			Уурхайн дарга болон байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	
3.	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	0	Төслийн хугацаанд			Уурхайн дарга болон байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	
4.	Байгаль орчны аудит хийлгэх	4861,0	7-р сард			Уурхайн дарга болон байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	
5.	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох				Уурхайн дарга	
Нийт		4861,0					

14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар

MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	<i>1</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>	<i>5</i>	<i>6</i>	<i>7</i>
<i>1.</i>	<i>Сум орон нутгийн иргэдийн нийтийн хуралд</i>	<i>Танилцуулах болон санал хүсэлт авах</i>	<i>Үйл ажиллагааны талаар</i>	<i>Жилд 1 удаа</i>	<i>750,0</i>	<i>Уурхайн дарга, Уурхайн байгаль орчин хариуцсан мэргэжилтэн,</i>	<i>Төв аймаг Заамар сум , Хайлааст баг</i>
<i>2.</i>	<i>Багийн засаг даргад</i>	<i>Танилцуулах болон санал хүсэлт авах</i>	<i>Нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлага</i>	<i>Жилд 1 удаа</i>	<i>Үйл ажиллагааны үярдал</i>	<i>Уурхайн байгаль орчин хариуцсан мэргэжилтэн,</i>	<i>Төв аймаг Заамар сум , Хайлааст баг</i>
<i>3.</i>	<i>Сум орон нутгийн ЗДТГ, Байгаль орчны байцаагч</i>	<i>Танилцуулах болон санал хүсэлт авах</i>	<i>Нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлага</i>	<i>Жилд 1 удаа</i>	<i>Үйл ажиллагааны үярдал</i>	<i>Уурхайн дарга, Уурхайн байгаль орчин хариуцсан мэргэжилтэн,</i>	<i>Төв аймаг Заамар сум ,</i>
<i>4.</i>	<i>БОАЖЯ-ны ХБОБНУГ-т</i>	<i>Тухайн жилийн БОМТ, тайлан</i>	<i>Тайлан хүлээн авсан актыг хүргүүлэх</i>	<i>Жилд 1 удаа 12-сард</i>	<i>Үйл ажиллагааны үярдал</i>	<i>Уурхайн байгаль орчин хариуцсан мэргэжилтэн,</i>	
	<i>Нийт</i>				<i>750,0</i>		

*МV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон
ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал

№	Арга хэмжээ	Зардал, сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	2,259
2	Нөхөн сэргээлт	24.5
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	15
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	0,2
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	0
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,88
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4,861
9	Орчны хяналт шинжилгээ	0,55
10	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах	0.75
	Нийт зардал, мян.төг	50.0

Тус уурхай нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 50.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж байна.

*MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Галтын амны алтны шороон ордын уурхайн 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*